



МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 19 өдөр

Дугаар

1/485

Улаанбаатар хот

Орон тооны жагсаалтад өөрчлөлт
оруулах тухай

Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын Ерөнхий хорооны 2009 оны 04 дүгээр хурлын протоколын 10.6 дахь заалт, Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дархан өртөөний харьяа Шарын гол өртөөний тооцооны операторч-тасалбарын нярав - 4 (дөрөв), Хөтөл өртөөний тооцооны операторч-тасалбарын нярав - 2 (хоёр), Салхит өртөөний тооцооны операторч-тасалбарын нярав - 2 (хоёр), нийт - 8 (найм) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс Дархан өртөөнд тооцооны операторч - 2 (хоёр), ачаа вагон хүлээлцэгч - 2 (хоёр) орон тоог нэмсүгэй.

2. Зүүнхараа өртөөний харьяа Үнэгт зөрлөгийн тасалбарын нярав-үйлчлэгч - 1 (нэг), Баруунхараа өртөөний ачаа тасалбарын нярав-ачаа вагон хүлээлцэгч-мэдээлэгч - 1 (нэг), Түнх өртөөний ачаа тасалбарын нярав-ачаа вагон хүлээлцэгч-мэдээлэгч - 1 (нэг), нийт - 3 (гурав) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс Зүүнхараа өртөөнд ачаа вагон хүлээлцэгч - 2 (хоёр), вагон бичигч-операторч - 3 (гурав) орон тоог нэмсүгэй.

3. Толгойт өртөөний харьяа Мандал өртөөний тооцооны операторч-тасалбарын нярав - 2 (хоёр) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс Аршаант өртөөнд тооцооны операторч-ачаа вагон хүлээлцэгч - 2 (хоёр), галт тэрэгний найруулагч IV зэрэг - 1 (нэг) орон тоог нэмсүгэй.

4. Улаанбаатар өртөөний харьяа Хонхор зөрлөгийн тооцооны операторч-тасалбарын нярав - 2 (хоёр), Улаанбаатар өртөөний тооцооны техникч II зэрэг - 1 (нэг) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс Амгалан өртөөнд ачаа вагон хүлээлцэгч - 2 (хоёр) орон тоог нэмсүгэй.

5. Багануур өртөөний буудал хариуцсан менежер - 1 (нэг) орон тоог 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хассугай.

6. Чойр өртөөний харьяа Олон-Овоо, Айраг, Бор-Өндөр, Шивээ-Овоо өртөөдийн тооцооны операторч-тасалбарын нярав - 13 (арван гурав) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс тооцооны операторч - 13 (арван гурав) болгон өөрчилж, Олон-Овоо өртөөнд ачаа вагон хүлээлцэгч - 1 (нэг) орон тоог нэмсүгэй.

1601252931

7. Сайншанд өртөөний ачигч (тээшийн) - 1 (нэг), ачаа тээвэр хариуцсан хэсгийн байцаагч - 1 (нэг), нийт 2 (хоёр) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хассугай.


8. Замын-Үүд өртөөний харьяа Улаан-Уул өртөөний тооцооны операторч-тасалбарын нярав - 1 (нэг) орон тоог 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хасаж, мөн өдрөөс ачаа тээвэр хариуцсан хэсгийн байцаагч - 1 (нэг) орон тоог нэмсүгэй.

9. Замын даргын 2024 оны А/909 дүгээр тушаалаар баталсан "Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн 2025 оны орон тооны жагсаалтын нэгтгэл"-д орох өөрчлөлтийг 1 дүгээр хавсралт, Дархан өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 2 дугаар хавсралт, Зүүнхараа өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 3 дугаар хавсралт, Толгойт өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 4 дүгээр хавсралт, Улаанбаатар өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 5 дугаар хавсралт, Багануур өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 6 дугаар хавсралт, Чойр өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 7 дугаар хавсралт, Сайншанд өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 8 дугаар хавсралт, Замын-Үүд өртөөний 2025 оны орон тооны жагсаалт"-д орох өөрчлөлтийг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

10. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Нийгэмлэгийн үндсэн цалингийн сүлжээнд нийцүүлэн Дархан өртөө, Зүүнхараа өртөө, Толгойт өртөө, Улаанбаатар өртөө, Багануур өртөө, Чойр өртөө, Сайншанд өртөө, Замын-Үүд өртөөний 2025 оны орон тоо, албан тушаал, үндсэн цалингийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

11. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (С.Я. Усольцева)-д даалгасугай.

ДАРГА



ХӨРЛЭН